



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/14

Хэрлэн сум

**Орон тооны бус шинжээч томилон
ажиллуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.29, эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулах, ажиллуулах журам батлах тухай А/402 тоот тушалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дэргэдэх орон тооны бус шинжээчийн багийг дараах бүрэлдэхүүнтэй 3 жилийн хугацаатай томилон ажиллуулсугай.

Орон тооны бус шинжээч:

Д.Баасандорж-ЭМГ-ын ахмад ажилтан, халдвар судлаач эмч

Х.Мөнхзул-Аймгийн Нэгдсэн эмнэлгийн ахмадын эмч

Ж.Хэрлэнцэцэг-АНЭ-ийн ахмад ажилтан, халдвартын эмч

2. Орон тооны бус шинжээчийн багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга /Х.Доржханд/, Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга /Д.Наранмичид/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Л.МЭНДБАЯР